

ӨВӨР МОНГОЛЫН ОРЧУУЛГЫН ҮЙЛСИЙН ХӨГЖЛИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Н.Улаан-Од ¹

Агуулгын товч

Энэхүү өгүүлэлд 1946-1976 оны хоорондох Өвөр Монголын орчин үеийн монгол-хятад орчуулгын үйлсийн түүхэн хөгжил, орчуулгын зохиол бүтээлийн ололт амжилтын тухай товч өгүүлэх болно.

Түлхүүр үг: Өвөр Монгол, зохиол бүтээл, орчуулга

Нэг

Монголчууд орчуулгын үйлээр дамжуулан дэлхийн олон үндэстэн ястны соёлыг өөрийн соёл иргэншлэлд шингээн авч байсан эртний сайхан уламжлалтай үндэстэн билээ. Өвөр Монголын орчин үеийн орчуулгын үйлсийн хөгжлийн түүх нь мөн чанар дээрээ солилцооны түүх, харилцааны түүх, нөлөөллийн түүхийн шинж чанартай соёлын түүх болж ирсэн юм.

Өвөр Монголын орчин үеийн монгол-хятад орчуулгын хөгжлийн шат үеийг: 1946-1966 оны хоорондох хөгжлийн гарааны эхлэл сууриа тавьсан үе;

1966-1976 оны хоорондох дан цулгай улс төрийн орчуулгын зохиол бүтээл давамгайлсан зогсонги үе;

1976-2011 оныг хүртэлх ололт амжилтаар дүүрэн үе гэж хувааж болох юм.

Өвөр Монголын орчуулгын үйлсийн хөгжлийн түүх нь, Монгол улсын орчуулгын соёлын нөлөөнөөс ихээхэн хамааралтай. Жишээлбэл: Монгол улсын нэрт эрдэмтэн Б.Содномоос: «Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв» (1946 он) хэмээх номондоо анх удаа «Орчуулгын утга зохиол» хэмээх ухагдахууныг дурдан гаргаж «Ганжуур», «Данжуур»-аар жишээ болгон судалсан байна. Ц.Дамдинсүрэн, Г.Жамсранжав нарын туурвисан «Монголын уран зохиолын тойм» (19-р зуун) бүтээлийн оршилд 19-р зууны эхэн үед, бүх монголчуудын эрдэмтэн, судлаачид орчуулгын үйлсийг ихээр сонирхож эхэлснийг дурджээ. Мөн уг номонд монгол, хятад уран зохиолын орчуулгыг чухалчлан үзсэн явдал нь Өвөр Монголын орчуулгын үйлсийн түүхэнд маш их ач холбогдолтой явдал болсон юм.

Үүнээс улбаалан Өвөр Монголын эрдэмтэн Рэнчингаваагийн «Монгол орчуулгын түүхийн хураангуй тойм», М.Баясгалан, Ринчин нарын «Орчуулгын ухааны суурь», Жинхуарын «Орчуулга зүй», С.Хичээлтийн «Орчуулгын ухааны үндсэн онол», Асралтын «Хятадыг монголчлох

¹ Өвөр Монголын Их Сургуулийн дэд профессор

орчуулгын анхны шинжлэлт», Пэрэнлэйн «Монгол орчуулгын найруулга», Чойжинжав нарын «Хятадыг монголчлох мэдлэг»... гэх мэтийн орчуулгын онолын номууд Өвөр Монголд хэвлэгдсэн байна. Эдгээр номонд орчуулгын тухай ерөнхий мэдлэг, үгсийн орчуулга, өгүүлбэрийн орчуулга, найруулгын орчуулга, орчуулагчдын бүрэлдүүлэх үндсэн нөхцөл, арга барилд оршиж байгаа асуудал болон анхаарах чухалтай асуудлуудыг хөндсөн байдаг.

Хоёр

Өвөр Монголын орчин үеийн уран зохиолын орчуулгын түүхийг 1947 оны 5-р сард ӨМӨЗО байгуулагдсанаар эхэлсэн гэж зарим эрдэмтэд үздэг. Үүний дараа сая Өвөр Монголд монгол-хятад хэлний орчуулгын үйлс хөгжлийнхөө гарааг тавьсан юм.

1946-1966 оны хооронд Өвөр Монголын уран зохиолын орчуулгын зохиол бүтээлийн хүрээнд Лю Байюнь: «Өрнөн цэцэглэж байгаа Бээжин хот» (1949 он), «Утга зохиолын тухай Мао Зэдуны өгүүлсэн нь», «Янь Аньд болсон утга зохиолын тухай ярилцах хурал дээр хэлсэн үг», Лу Шуний: «А Кюгийн үнэн түүх», «Архины мухлагт», «Маргааш», «Хашгираан», «Эргэлзэл», Гүө Мөрүэгийн «Дагина», «Эх болсон дэлхий минь», Жао Шүлигийн: «Ли Зя тосгоны хувиралт», «Сяо Эрхэ ураг барилдсан нь», Жоу Либөгийн: «Догшин салхи, шүрүүн бороо», Тянь Хань: «Мөрний өмнөд тосгоны бага үзэмж», Ма Пингийн: «Бодлогогүй хүн» зэрэг зохиол бүтээлийг монгол хэлээр чанартай сайн орчуулсан байна.

Энэ хугацаанд Өвөр монголын орчуулгын үйлс «Хувьсгалд үйлчлэх, ард түмэнд үйлчлэх» зорилгыг үндсэн чиглэлээ болгон, олон ном зохиол орчуулан хэвлүүлж байсан боловч «Их үсрэнгүй дэвшилт», «Баруунтныг эсэргүүцэх», «Засварлах үзлийг эсэргүүцэх ба сэргийлэх» зэрэг хөдөлгөөний шууд нөлөөн дор, идэвхтэй хөгжиж байсан орчуулгын үйлс аажмаар зогсонги шатанд орсон юм. Гэвч олсон ололт амжилт чамгүй их байж, олонхи орчуулгын бүтээлүүдийг энэ үед анх удаа хэвлэсэн юм.

1966-1976 оны «Соёлын хувьсгал»-ын бужигнаант он жилүүдийн дунд зөвхөн «Мао Зэдуны зохиолын түүвэр», «Мао Зэдуны зохиолын сонгомол», «Мао Зэдуны шүлэг дуулал хорин нэгэн бадаг», «Мао Зэдуны шүлэг дуулал гучин долоон бадаг», «Монгол-хятад харьцуулсан Мао Зэдуны шүлэг дуулал», «Хээрийн өвс», «Халуун салхи», «Монгол-хятад харьцуулсан Лу Шуний шүлгийн түүвэр», «Монгол-хятад харьцуулсан Лу Шуний өгүүлэгийн түүвэр», «Лу Шуний ёгт өгүүллийн түүвэр» зэрэг цөөн хэдэн зохиол бүтээл монгол хэлээр орчуулагдан хэвлэгджээ. Цаг үеийн хорио цээрээс болж, энэ үед монгол уран зохиол бараг орчуулагдан хэвлэгдсэнгүй гэж хэлэхэд хилсдэхгүй юм.

1946-1976 он хүртэлх гучин жилийн хугацаанд орчуулагдсан уран зохиолын бүтээлээс ажиглавал туужсын зохиол 15, тууж 3, роман 2, утга урлагийн онолын ном 4, өгүүллийн түүвэр 3, найрууллын түүвэр 2, жүжгийн ном 1, ёгт өгүүлэл шүүмжийн түүвэр 2, мэдээллийн уран зохиолын түүвэр 4-н дэвтэр тус тус орчуулагдан хэвлэгджээ. «Өвөр монголын өдрийн сонин»-д 9 шүлэг найраглал, 2 найруулал, 3 шүүмж орчуулагдаж, «Өнөр цэцэг» сэтгүүлд 12 шүлэг найраглал, 3 өгүүлэл, 1 тууж, 1 жүжиг, 6 шүүмж орчуулагдаж, «Монгол хэл бичиг» сэтгүүлд 3 шүүмж орчуулагджээ. «Өнөр цэцэг» сэтгүүлд орчуулагдсан зохиолын тоо хамгийн олон байж, 23 зохиол орчуулагдаж, дараад нь «Өвөр Монголын өдрийн сонин»-д орчуулагдсан зохиол 14 болж, бусад сонин сэтгүүлд цөөн хэдэн зохиол бүтээл орчуулагдсан байна.

«Соёлын хувьсгал»-ын дараа үзэл суртлын хүрээнд хэдийгээр орчуулгын ажлыг тийм их

чухалчлан үзэж байгаагүй боловч, өнгөрсөн зууны наяд оны эхэн хүртэл Өвөр Монголын орчуулгын үйлс сэргэн хөгжих шатандаа орсон юм. 1946-1976 он хүртэлх хугацаанд Өвөр Монголд хятад зохиол бүтээлийг монголчлох орчуулгын ажлыг нэлээд сайн хийж байсан гуч гаруйхан орчуулагч байжээ. Үүнд Н.Сайнцогт, Гэрэлцогт, Пэрэнлэй, Содном, Бат, Сүлфүнгаа, Содбилэг, Эрдэмтөгс, Ринчингаваа, Жигжид, Хишигжаргал, Боргил, Дугарсүрэн, Манижав, Хасчулуу, Хасгэрэл, Номин, Насан, Норбуу, Халин, Даш, Сод зэрэг хүмүүс нь нэлээд олон хятад зохиолыг орчуулсан байна. Энэ үед манай оронд сайн чанартай орчуулгын гол гол зохиол бүтээл хэвлэгдэн тархсан юм.

Гурав

Манай оронд Монгол улсын орчин үеийн зохиол бүтээлийг орчуулах ажил, 1953 оноос 1963 оны хооронд өрнүүн хөгжсөн бөгөөд, түүнээс хойшх хагас зууны дотор энэхүү амжилтаа давж гараагүй байна. Энэ хугацаанд Чэн Найшүн, Пэн Сайкай, Дин Шүхао, Юй Пин, Шүн Юаньпин, Вэнь Шү, Лү Цин, Жан Юйюань, Цай Шинбао, Сао Зян, Сао Фэн, Вэнь Жүнхэ, Фань Юньхун, Чи Шиньбао, Тао Мөна, Фэнь Сы, Сэдорж, Хурц, Анчинхүү, Номин, Сод зэрэг орчуулагчид Монгол Улсын орчин үеийн зохиол бүтээлийг орчуулан хэвлүүлэх ажилд маш их хувь нэмрээ оруулжээ. Мөн Монгол улсын Д.Нацагдоржийн жүжиг «Учиртай гурван толгой», «Миний нутаг», Ц.Дамдинсүрэнгийн «Солийг сольсон нь», Ц.Лодойдамбын «Манай сургуулийнхан», Б.Ринчений «Үүрийн туяа», Ц.Гайтавын «Дамдины Сүхбаатар», Д.Сэнгээгийн «Аюуш», «Зүрх судас хоёр» зэрэг ахмад үеийнхний зохиосон шилдэг бүтээлүүдийг цөм энэ үед манай оронд орчуулсан байна.

БНХАУ-д Монгол улсын орчин үеийн зохиол бүтээлийг орчуулгын түүхийг өгүүлэхэд ЗХУ-ын эрдэмтэн Г.И.Михайловын бичсэн «Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал»-ыг эрхбиш дурдах чухалтай. Тус номыг манай улсад 1958 онд хятад, монгол хэлэнд орчуулан гаргасан юм. Уг номын хэвлэгдсэн явдал нь манай улс дахь Монгол улсын орчин үеийн зохиол бүтээлийн орчуулгын үйлсэд нэн их ач холбогдол өгсөн юм.

Монгол Улсын орчин үеийн зохиол бүтээлийг орчуулсан шүүмж өгүүллийг голдуу манай улсын «Гуан Мин өдрийн сонин», «Вэнь Хүйбао сонин», «Ши Чүйбао сонин», «Вэнь И-бао сонин», «Ардын өдрийн сонин», «Шань Ши өдрийн сонин», «Өвөр монголын өдрийн сонин», «Утга зохиолын сарын сэтгүүл», «Утга зохиолын шүүмжлэл» сэтгүүл, «И Вэнь» сэтгүүл, «Дэлхийн утга зохиол» сэтгүүл зэрэг арав гаруй сонин сэтгүүлд нийтэлдэг юм. Тухайн жилүүдэд орчуулагдан нийтлэгдсэн зохиол бүтээлүүд нь хэдийгээр эрдэм шинжилгээ, судалгааны тусгай салбар болж чадаагүй боловч, харин хоёр улсын улс төр болон соёлын харилцаа холбоог эрчимжүүлэхэд суурь болж өгсөн найрсаг харьцааны бүтээгдэхүүн болон үлдсэн нь харагдана.

1957 онд манай улсад орчуулагдсан «Хөгжиж байгаа Монголын утга зохиол» болон 1958 онд орчуулагдсан «Монголын орчин үеийн уран зохиол» хэмээх хоёр өгүүлэл нь тухайн үед Монголын уран зохиолын түүхэн бичлэгийн арга барил, эрдэм шинжилгээний өнцгөөс нэлээд системтэй танилцуулсан орчуулгын бүтээл болсон гэж үнэлдэг. Эдгээр өгүүлэлд Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж, Д.Сэнгээ, Ч.Чимэд, М.Гаадамба, Ц.Лодойдамба зэрэг Монгол улсын орчин үеийн уран зохиолд жинтэй нөлөө үзүүлсэн нэрт зохиолчдын содон сайхан зохиол бүтээлийг нарийн танилцуулсан байна.

1961 оны 7 сарын 15-н өдөр Манай улсын «Шань Ши өдрийн сонин»-д орчуулан нийтэлсэн Ма Жяжүний: «Монгол утга зохиол ба БНХАУ» хэмээх шүүмж нь голдуу Хятад, Монголын найрсаг харилцааг товойлгож, Монголын түүхэн уран зохиол ба орчин үеийн уран зохиолын хөгжлийн явц болон Хятад, Монгол хоёр орны утга зохиолын солилцоог ерөнхийлөн өгүүлжээ. 1961 оны 7 сарын 18-н өдөр «Өвөр монголын өдрийн сонин»-д Бөхийн хятадаар бичсэн: «БНМАУ-ын соёл урлагийн үйлсийн элбэг амжилт» гэх сонины мэдээний шинжтэй шүүмж өгүүллийг нийтэлж, Монгол улсын боловсрол, соёл урлагийн олсон амжилт бүтээлийг хураангуйлан танилцуулж, Хятад, Монголын найрсаг харилцаа болон ӨМӨЗО-ны үндэстнүүдээс Монгол улсын урлагийн бүлгэмийн тоглолтыг сонирхсоны дараах мэндчилгээгээ дамжуулсан байна.

1956 оны Хятадын «Ши Чүйбао сонин»-д Пан Рун: «Монголын ард түмний амьдралыг зурагласан Бээжин ши <учиртай гурван толгой>» хэмээх өгүүллийг хятад хэлээр нийтэлж, Монголын шилдэг жүжгийн зохиол «Учиртай гурван толгой», Хятад улсын ши жүжгийн хэв маягаар тайзнаа тавигдсан байдлыг өгүүлэн, энэхүү үйл ажиллагааны ач холбогдлыг өндрөөр үнэлсэн байна.

Монгол Улсын орчин үеийн зохиол бүтээлийг орчуулах ажил жинхэнэ утгаараа 1980 оноос хойш, манай оронд эрчимтэй хөгжих шатандаа орсон байна. Үүнээс өмнөх хорь гаруй жилд нь хүйтэн дайны нөлөө болон «Соёлын хувьгал»-ын үймээнээс болж Монгол улсын зохиол бүтээлийг орчуулах ажил нэлээд олон жил тасалдсан түүхтэй юм. Гэвч Өвөр Монголын орчуулгын үйлс нь хөгжлийнхээ явцдаа ухамсартай буюу ухамсаргүйгээр бусад үндэстний соёлын үр нөлөө болон үр шимийг байнга шингээн авч, «Орчуулгын солилцоо», «Тайлбарлал ба дахин бүтээх», «Бүтээлч чанартай шинийг үүдэх» зэрэг хувьсал өөрчлөлтийн замыг туулан, харилцан нөлөөлж, хамтаар орших харьцааны дунд хөгжиж, үндэстэн хоорондын соёлын солилцоонд идэвхтэй хувь нэмэр оруулсан байна.

Дөрөв

Өвөр монголын орчуулгын үйлсийн өнөөгийн байдлыг ерөнхийд нь авч үзвэл, доорх хэдэн талын онцлогтой:

(1). Сүүлийн жилд манай оронд нийтлэгдэж байгаа эрдэм шинжилгээний бүтээлийн дотор орчуулгын судалгааны чанартай бүтээл цөөрч, хэдхэн ном зохиолоос ши авч, ерөнхийд нь танилцуулах хэлбэрийн өгүүлэл, илтгэл ганц хоёр нийтлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл орчуулгын тухай гүнзгий системтэй судалгааны ажил эрчимтэй хөгжөөгүй байна гэсэн үг.

(2). Өвөр Монголд олон зүйлийн шалтгаанаас болж, орчуулгын мэргэжил, орчуулах ур чадварыг тусгай заах багш нарын эгнээ, өмнөх үетэй харьцуулбал одоо хэр нь бүрэлдэж чадаагүй байгаа нь, жинхэнэ орчуулгын судалгааны эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй зохиол бүтээл туурвих залуу үе төрөн гарч чадахгүй байгаатай шууд холбоотой асуудал бий.

(3). Өвөр Монголын их дээд сургууль, албан байгууллагуудад сурч ажиллаж байгаа, эрдмийн зэрэг цолоор нэлээд өндөр боловч, өсч төрсөн, сурч хүмүүжсэн орчин нөхцлөөс нь шалтгаалаад орчуулгын мэдлэгийн тухай тааруухан ойлголтой залуучууд олноор бий болж байна. Эдгээр залуучуудын хэлдэг үгсийнх нь тэн хагас нь хятад үг болсон тул орчуулга бараг хэрэггүй илүү ажил гэсэн үзэлттэй болжээ.

(4). Өвөр Монголд хэвлэгдсэн орчуулгын зохиол бүтээлд монгол хэлний үгийн сангийн

тансаг баялаг үг хэллэг маш цөөн харагдаж байна. Дийлэнх орчуулгын зохиол бүтээлийнх нь зарим үг өгүүлбэрийг нь ойлгохгүй, юу хэлэх гэсэн юм бол? гээд тунгаан үзэж байж сая нэг хятад үгийнх нь утгаар ийм санааг гаргах гэж оролджээ гэж ухаарч байдаг.

(5). Өвөр Монголд «модон хэлтэй» буюу толь бичиг эргүүлсэн, машин шиг «махчлан орчуулах» олон “орчуулагч” бий болж байна. Иймээс юун гадаадын сонгодог бүтээлийг орчуулах, монголчуудын эртний бичиг судрыг хөрвүүлэх, хятадын эртний үсэг бичгийг тайлах, мөн дипломат орчуулгын мэдлэг мэргэжлийг эзэмших тухай ярих ч хэрэггүй болж байна.

Харин Монгол улсын нэгэн үеийн нэрт мэргэжлийн орчуулагчдын ачаар, Өвөр Монголд дэлхийн уран зохиолын маш олон сонгодог бүтээлүүд кирилл үсгээс уйгуржин монгол бичигт хөрвүүлэгдэн хэвлэгдсэн явдал нь, манай орны орчуулгын зохиол бүтээлийн үнэт зүйл болж үлдсэн байна. Үүнд зарим бүтээлээс нь дурдвал:

1. Ц.Дамдинсүрэн нар. «Монголын тууж өгүүллэгийн түүвэр». Хятадын соёл амьдралын хэвлэлийн хороо. 1953 он.
2. Д.Цэвэгмид. «Нар гэрэлтүүлсэн эрх чөлөөт Монгол». Шанхайн утга зохиолын холбооны хэвлэлийн хороо. 1954 он.
3. Д.Сэнгээ. «Аюуш». Зохиолчдын хэвлэлийн хороо. 1955 он.
4. Ц.Лодойдамба. «Манай сургуулийнхан». Зохиолчдын хэвлэлийн хороо. 1955 он.
5. Д.Нацагдорж. «Миний эх орон БНМАУ». Шинэ утга зохиол хэвлэлийн хороо. 1955 он.
6. Д.Тарва. «Дамрины гэр бүл». Зохиолчдын хэвлэлийн хороо. 1956 он.
7. Д.Цэвэгмид. «Булшин дээр». Зохиолчдын хэвлэлийн хороо. 1956 он.
8. Ц.Лодойдамба. «Алтайд». Зохиолчдын хэвлэлийн хороо. 1956 он.
9. Ц.Лодойдамба. «Малгайтай чоно». Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1956 он.
10. Д.Нацагдорж. «Учиртай гурван толгой». Хятадын жүжгийн хэвлэлийн хороо. 1957 он.
11. Чойж. «Улаан тугийн гавъяаны одон». Хятадын жүжгийн хэвлэлийн хороо. 1957 он.
12. Б.Ринчин. «Үүрийн туяа». Ардын утга зохиолын хэвлэлийн хороо. 1958, 1962 он.
13. «Ц.Цэдэнжавын яруу найргийн сонгомол». Шанхайн утга зохиолын хэвлэлийн хороо. 1959 он.
14. Ч.Ойдовын. «Зам». Хятадын жүжгийн хэвлэлийн хороо. 1960 он.
15. «Ц.Дамдинсүрэнгийн яруу найргийн сонгомол». Зохиолчдын хэвлэлийн хороо. 1961 он.
16. Л.Дашдэндэв. «Гэрэлт зам». Зохиолчдын хэвлэлийн хороо. 1961 он.
17. Ц.Гайтав. «Сүхбаатарын магтаал». Шанхайн утга зохиолын хэвлэлийн хороо. 1962 он.
18. Д.Сэнгээ. «Гүн хайр». Зохиолчдын хэвлэлийн хороо. 1962 он.
19. Д.Нацагдорж. «Цагаан сар ба хар нулимс». Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1980 он.
20. Ц.Лодойдамба. «Тунгалаг тамир». Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1984 он.
21. «Б.Лхагвасүрэнгийн яруу найргийн сонгомол». Үндэстний хэвлэлийн хороо. 2008 он гэх мэтийн зохиол бүтээл хэвлэгдсэн байна.

Ашигласан материал

1. Цэнгэлтэй: «Монгол Улсад явсан тэмдэглэл». «Өвөр монголын өдрийн сонин». 1953 оны 2-р сарын 6-ны өдөр.
2. Манижав: «Монгол Улсын шинэ утга зохиол». «Өвөр монголын өдрийн сонин». 1953 оны 7-р сарын 11-ны өдөр.
3. Пэлия: «Нацагдоржийн зохиолын сэдэв ба хэлний тухай шүүмж». Өвөр монголын «Өнөр цэцэг» сэтгүүлийн 1957 оны 2-р хугацаа.
4. Ц.Дамдинсүрэн: «Монголын уран зохиолын товч өгүүлэл». Өвөр монголын «Монгол түүх хэл бичиг» сэтгүүлийн 1958 оны 6-р хугацаа.
5. И.Михайлов: «Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал». Пэлия орчуулав. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1958 он.
6. Н. Улаан-Од, Мэнд нар: «Хятадын орчин үеийн монгол зохиолчдын өгүүллэгийн түүвэр». Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1989 он.
7. Н. Улаан-Од: «Монголын зохиолч ба зохиол бүтээлийн танилцуулга». Алшаагийн сонин 1991 он 1-р хуудас.
8. Н.Улаан-Од: «Монгол Улсын сонин сэтгүүлийн өгүүллийн гарчиг» (1965---1985). ном. Хөх хот. 1992 он.
9. Н.Улаан-Од: «Монгол Улсын уран зохиолын хөгжилт». Өвөр Монголын «Хун галуу» сэтгүүл. 2009 оны 8-р хугацаа.
10. Үүлэнхуар: «Монгол судлалын монгол ном өгүүлийн хэлхээс» (1991-1995). 2005 он.